



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр орсон өөрчлөлтөөр малчдын өндөр насны тэтгэвэр тогтоох насыг 5 жилээр багасган тогтоож, 2018 оноос хэрэгжүүлж байна.

Тус хуулийн дагуу 2018 онд 15-20 жил малчнаар ажилласан 55-60 насны эрэгтэй, 50-55 насны эмэгтэй нийт 13500 орчим иргэн тэтгэвэр тогтоолгох урьдчилсан тооцоо байна.

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор малчнаар ажилласныг тодорхойлоход “Мал тэжээвэр амьтад, хашаа худгийн ... оны тооллого”-ын бүртгэл, лавлагааг, Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн дагуу ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн тооцуулсан тухай нийгмийн даатгалын байгууллагаас олгосон баримт, лавлагаа, иргэний үнэмлэхний хуулбар авах шаардлагатай болсон тул Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтад энэ лавлагаа бүртгэл, баримт бичгийг тэтгэвэр тогтооход бүрдүүлэх баримт бичгээр оруулах шаардлагатай байна.

Учир нь одоо мөрдөж байгаа Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд тэтгэвэр тогтооход бүрдүүлэх, ажилласан жилийг тодорхойлж нотлоход шаардлагатай баримт бичгүүдийг хуульчилсан байгаа хэдий ч эдгээр баримт бичгүүдээр малчдын малчнаар ажилласан жилийг тодорхойлж нотлох боломжгүй байна.

Малчнаар ажилласан хугацааг тодорхойлох, тэтгэвэр тогтооход шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэх талаар хуулийн зохицуулалт дутмаг, нийгмийн даатгалын байгууллага хуульд заагаагүй баримт бичгийг малчдаас шаардах боломжгүйн улмаас малчны малчнаар ажилласан хугацааг тогтооход хүндрэлтэй нөхцөл байдал үүсээд байна.

Иймд нийгмийн даатгалын байгууллагаас хуулийг хэрэгжүүлэх, малчдад тэтгэвэр тогтоох үйл ажиллагааг шуурхай, чирэгдэлгүй явуулах нөхцөл

бүрдүүлэхийн тулд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд тэтгэвэр, тэтгэмж тогтооход бүрдүүлэх баримт бичгийн бүрэлдэхүүнд малчнаар ажилласан жилийг тодорхойлох зарим баримт бичгийг нэмж оруулах хэрэгцээ, шаардлага бий болоод байна.

Түүнчлэн 1994 оны 06 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт хөдөлмөрийн хэвийн бус нөхцөл болох газрын дор, халуун, хортой, хүнд нөхцөлд ажилласан даатгуулагч хуульд заасан болзлыг хангасан тохиолдолд өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй байхаар хуульчилсан байсан.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1997 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн хуулиар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг өөрчлөн найруулж, зөвхөн газрын дор болон халуун нөхцөлд ажиллаж байсан даатгуулагчийн өндөр насны тэтгэвэр авах болзлыг зохицуулсан. Өөрөөр хэлбэл хөдөлмөрийн хортой, хүнд нөхцөлд ажиллаж байсан даатгуулагчид өндөр насны тэтгэвэр тогтоох харилцааг зохицуулж байсан 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 3 дахь заалтыг хүчингүй болгосон.

Энэхүү хуулийг хэрэгжүүлэх зорилгоор 1997 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хууль батлагдсан юм.

Тус хуулийн 2 дугаар зүйлд 1999 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр өөрчлөлт оруулсан ба энэхүү өөрчлөлтөөр Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан тэтгэвэр авах нөхцөл, болзлыг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллагчдын тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдсон харилцааг зохицуулсан хууль батлагдаж хүчин төгөлдөр болох хүртэл хэрэглэж байхаар болсон. Үүний дагуу хөдөлмөрийн хортой, хүнд нөхцөлд ажилласан даатгуулагчийн өндөр насны тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд тогтоож ирсэн билээ.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, хуулийн зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай хуулиудыг хэрэглэх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар дээрх 2 дугаар зүйлийг өөрчлөн найруулснаар хөдөлмөрийн хортой, хүнд нөхцөлд ажилласан даатгуулагчийн тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох эрх зүйн үндэслэлгүй болсон.

Хөдөлмөрийн хортой, хүнд нөхцөлд ажилласан даатгуулагчийн тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох хууль, эрх зүйн зохицуулалт байхгүйн улмаас хөдөлмөрийн хортой, хүнд нөхцөлд ажиллаж буй тэтгэвэр тогтоолгох нас ойртсон даатгуулагч иргэдэд бухимдал үүсгэж, үйлдвэрчний эвлэлийн холбоод, төрийн бус

байгууллага, иргэдээс холбогдох хуулийн зохицуулалтыг нэмж тусгуулах талаар албан бичиг, өргөдөл, санал хүсэлт олноор ирж байгаа тул Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд хөдөлмөрийн хортой, хүнд нөхцөлд ажилласан даатгуулагчийн тэтгэврийг хөнгөлөлттэй нөхцөлөөр тогтоох эрх зүйн зохицуулалтыг нэмэлтээр оруулах шаардлагатай байна.

Өнөөгийн байдлаар нийгмийн даатгалын сангаас хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр 27.9 мянга гаруй иргэн тэтгэвэр авч байна. Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр жилд дунджаар 2800 даатгуулагч шинээр тэтгэвэр тогтоолгодог бөгөөд үүний 80 орчим хувь нь хөдөлмөрийн хүнд, хортой нөхцөлийн тэтгэвэр авагчид байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5.2-т заасан хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн төрлөөр боловсруулна. Хуулийн төсөл 3 зүйлээс бүрдэнэ.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар малчид болон хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлөөр тэтгэвэр тогтоох харилцаа тодорхой болж, Нийгмийн даатгалын байгууллага хуулийн заалтыг нэг мөр хэрэгжүүлж, даатгуулагчид тэтгэвэр тогтоолгох үйл ажиллагаа чирэгдэлгүй, шуурхай болж улмаар ахмадуудын орлогын баталгаа сайжрах зэрэг нийгэм, эдийн засгийн эерэг үр дагавар бий болно.

Нийгмийн даатгалын сангийн 2018 төсвийн тухай хуульд тэтгэврийн даатгалын сангийн зарлагын төсөвт 1.619,7 тэрбум төгрөгийг зарцуулахаар тусгасан тул хууль батлагдаж, хэрэгжсэнээр улсын болон нийгмийн даатгалын сангийн төсөвт нэмэлт эх үүсвэр шаардагдахгүй.

Дөрөв.Хуулийн төсөл нь Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Нийгмийн даатгалын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулна.

Энэхүү хуулийн төслийг дагалдуулан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулна.